# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/307 Номгон

"Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.4, 15.1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" зорилтот арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөг хэрэгжилтийг хангах зорилгоор "Найз байя" аяны хүрээнд шилдэг "Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдаан зарласугай

2."Найз байя" аяны хүрээнд шилдэг "Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах 5.000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-т, зохион байгуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Н.Мэндбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

0310767

Аймгийн Засаг даргын ..........оны ..... дугаар
сарын ..........-ны өдрийн ..........дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 06 дугаар сарын 02 Номгон

"Найз байя" аяны хүрээнд шилдэг "Хүүхэд хамгааллын баг"
шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай

Нэг. ЗОРИЛГО

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлын уялдаа холбоог нягтруулж сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх сурагч, багш, эцэг эх, хүүхдэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг сэргээн идэвхжүүлэн хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтын үр дүнг бататгаснаар сургууль болон гэр бүлийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл дарамт, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтыг бууруулахад оршино.

**Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ**

- Аймгийн нийт 31 сургууль, 35 цэцэрлэг хамрагдана.

**Гурав. ХУГАЦАА**

2023 оны 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдана.

**Дөрөв. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛЛАЛТ**

4.1.Сургууль, цэцэрлэгүүд нь болзолт уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах

4.2.Болзолт уралдаан зохион байгуулсан тайланг холбогдох баримт материалын хамт 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт ирүүлэх

4.3.Болзолт уралдааны шалгаруулалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газрын хамтарсан ажлын хэсэг шалгаруулах

**Тав.АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

Цахим контент, нэвтрүүлэг

"Найз байя" аянг оновчтой, үр дүнтэй арга аргачлал

Аймгийн Засаг даргын ........оны ..... дугаар
сарын ..........-ны өдрийн .........дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 06 дугаар сарын 02 Номгон

"Найз байя" аяны хүрээнд шилдэг "Хүүхэд хамгааллын баг"
шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай

Нэг. ЗОРИЛГО

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлын уялдаа холбоог нягтруулж сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх сурагч, багш, эцэг эх, хүүхдэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг сэргээн идэвхжүүлэн хүүхэд хүмүүжлийн зерэг арга сургалтын үр дүнг бататгаснаар сургууль болон гэр бүлийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл дарамт, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтыг бууруулахад оршино.

**Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ**

- Аймгийн нийт 31 сургууль, 35 цэцэрлэг хамрагдана.

**Гурав. ХУГАЦАА**

2023 оны 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдана.

**Дөрөв. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛЛАЛТ**

4.1.Сургууль, цэцэрлэгүүд нь болзолт уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах

4.2.Болзолт уралдаан зохион байгуулсан тайланг холбогдох баримт материалын хамт 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт ирүүлэх

4.3.Болзолт уралдааны шалгаруулалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газрын хамтарсан ажлын хэсэг шалгаруулах

**Тав.АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

Цахим контент, нэвтрүүлэг

"Найз байя" аянг оновчтой, үр дүнтэй арга аргачлал

Нөлөөллийн арга хэмжээ

- Хүүхэд хүмүүжлийн арга аргачлал
- Танин мэдэхүйн арга аргачлал
- Оролцоонд тулгуурласан арга аргачлал
- Хамтын ажиллагаанд суурилсан арга аргачлал ... г.м

**Зургаа. Шалгуур үзүүлэлт**

6.1.Сургууль бүр дарамт дээрэлхэлт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс хүүхэд нэг бүрийг хамгаалах, хүмүүжлийн зерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, сурагчдад тулгамдаж буй асуудлыг илрүүлэн сар бүр шинэлэг ажил арга хэмжээ зохион байгуулж, ажил арга хэмжээ бүрийг дүгнэн алдаршуулсан байх.

6.2.Болзолт уралдааны хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээ нь сурагчид, багш ажилчид, эцэг эх гэсэн зорилтот бүлгүүдийг хамруулсан байх

6.3.Үйл ажиллагаа тус бүрийг баримтжуулсан байх /зураг, гарын үсэг г.м/

6.4.Зохион байгуулсан ажлыг тухай бүрт нь "ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГЫН СУРГАГЧ БАГШ НАР- БАЯНХОНГОР", "БАЯНХОНГОР АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР" цахим хаягт байршуулах

6.5.Үйл ажиллагааг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах

6.6.Хүүхэд хүмүүжлийн зерэг аргын 7 модуль сургалтыг сургуулийн нийт багш, ажилтныг хамруулан зохион байгуулах

6.7.Тухайн сургуулийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтын статистик 5-аас доошгүй хувиар буурсан байх

6.8.Сургагч багш нараар дамжуулан сургуулийн нийт эцэг эхчүүдийн 80-аас доошгүй хувьд нь хүмүүжлийн зерэг аргын сургалтыг зохион байгуулсан байх

6.9.Багш бүр өдөр тутмын хичээл сургалтын үйл ажиллагаандаа хүүхэд хүмүүжлийн зерэг аргыг хэрэглэснээр хүүхэд бүрийн сурах хөгжих идэвх санаачилга нэмэгдэж улмаар сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт сайжирсан байх

6.10.Сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн статистик 5%-иар буурсан байх

6.11.Үе тэнгийнхний дээрэлхэлт сургуулийн орчинд буурсан байх

6.12.Кейс дээр ажиллаж үр дүнд хүрсэн байх

**Долоо. Шагнал урамшуулал**

7.1.Шилдэг хүүхэд хамгааллын баг-сургууль /Үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан баримтжуулалт зэргийг харгалзан гарсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг дүгнэнэ/

1-р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

2- р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

7.2.Шилдэг хүүхэд хамгааллын баг-цэцэрлэг /Үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан баримтжуулалт зэргийг харгалзан гарсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг дүгнэнэ/

1-р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

2- р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр Өргөмжлөл, мөнгөн шагнал

________oOo________

Аймгийн Засаг даргын ..........оны ...... дугаар
сарын ..........-ны өдрийн ........ дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

## "ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛ, ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛД ХАМТДАА" АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Болзолт уралдааныг дүгнэх /ажлын хэсэг зарим сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах/ | Хүн | 6 | 64.000*3 | 1.152.000 |
| 2 | Шатахууны зардал | литр | 200 | 2530 | 506.000 |
| 3 | Мөнгөн шагнал | | | | 3.342.000 |
| | | | | **Нийт дүн 5.000.000** | |

_________oOo_________